



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/2/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Г.Даваасүрэн

Утас:70350757

Цахим хаяг:davaasureng@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Еранхйи зүйл.....	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 16
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Х.ЭРДЭНЭБАТ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн /Улсын төсөв/ 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн /Улсын төсөв 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН ХЭДС 2020

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>827,621,426.00</u>	<u>774,193,850.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	827,621,426.00	774,193,850.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	71,326,926.00	10,002,400.00
336	Зээлийн авлага	756,294,500.00	764,191,450.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	756,294,500.00	764,191,450.00
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33612	Хувь хүмүүст олгосон зээл	756,294,500.00	764,191,450.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>827,621,426.00</u>	<u>774,193,850.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>69,500.00</u>	<u>68,062,302.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	69,500.00	68,062,302.00
413	Өглөг	69,500.00	68,062,302.00
4136	Бусад өглөг	69,500.00	68,062,302.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	67,992,802.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	69,500.00	69,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>827,551,926.00</u>	<u>706,131,548.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	827,551,926.00	706,131,548.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	827,551,926.00	706,131,548.00
51210	Өмнөх үеийн үр дүн	578,825,267.00	827,551,926.00

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	248,726,659.00	(121,420,378.00)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	827,621,426.00	774,193,850.00

/Төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өнөх оны үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	665,769,244.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	665,769,244.00
110	Орлогын албан татвар	-	665,769,244.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	665,769,244.00
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		
110002	Үйл ажиллагааны орлого		584,546,100.00
110008	Шууд бус орлого		81,223,144.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	787,189,622.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	787,189,622.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,579,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,032,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,032,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,547,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,547,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	779,610,522.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	373,992,802.00

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		373,992,802.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,967,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,967,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	393,650,720.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		393,650,720.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(121,420,378.00)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	(121,420,378.00)

2.3 Аудит хийсэн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	916,872,294.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	332,326,194.00
110	Орлогын албан татвар	-	332,326,194.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	332,326,194.00
110002	Үйл ажиллагааны орлого		251,103,050.00
110008	Шууд бус орлого		81,223,144.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	584,546,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	301,000,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		301,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	283,546,100.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		16,514,000.00

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		267,032,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	916,872,294.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	916,872,294.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	7,579,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,032,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,032,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,547,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,547,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	909,293,194.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	565,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		565,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	81,223,144.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		81,223,144.00
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	11,967,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,967,000.00
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	251,103,050.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		251,103,050.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн санхүүгийн өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	827,551,926.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			827,551,926.00		827,551,926.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	827,551,926.00	-	827,551,926.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D08	Тайлант үеийн үр дүн			(121,420,378.00)		(121,420,378.00)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	706,131,548.00	-	706,131,548.00

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэмэлт санхүүжилтийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	267,032,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	267,032,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,032,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,032,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,032,100.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	265,000,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	265,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		265,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,853,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		5,853,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	272,885,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	272,885,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		5,853,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		267,032,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	722245300.00	572579100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	722245300.00	572579100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	19546100.00	7579100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	3,032,100.00	3,032,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			3,032,100.00	3,032,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	16,514,000.00	4,547,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			16,514,000.00	4,547,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	702,699,200.00	565,000,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	702,699,200.00	565,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			702,699,200.00	565,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	584,546,100.00

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	568,032,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих				
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих				568,032,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих				
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	16,514,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих				16,514,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Х.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч авлага барагдуулаагүй талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Г.Даваасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 01/128 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- (Халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэх, энэ чиглэлийн төрийн бодлого хэрэгжүүлэх)

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа Орхон аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь 2020 онд шилэн дансанд хяналт хийгээгүй бөгөөд шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар улирал бүр тайлангаа хоцроож илгээж байна.

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд авч үзээгүй бөгөөд дараагийн аудитаар эрсдэлд оруулах нь зөв гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 421,620.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,216.2 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлогын дүн жилийн дүн тул 665,769.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,657.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,427.6 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	827,621.4	774,193.8	(53,427.6)
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	827,621.4	774,193.8	(53,427.6)
Өр төлбөр	69.5	68,062.302	67,992.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	827,551.9	706,131.5	(121,420.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	827,621.4	774,193.8	(53,427.6)

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь 2015, 2017 онуудад Аж ахуй нэгж байгууллага, хувь хүмүүст олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага буурснаас шалтгаалж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын ковид 19 цар тахалтай Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт 29,1 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 15,2 сая төгрөг, нийтийг хамарсан ажил үйлчилгээ хөтөлбөрт 20.4 сая төгрөгийн хөтөлбөр хэрэгжүүл гэсэн чиглэл ирсний дагуу судалгаа хийж зээл авах иргэд аж ахуй нэгжээс сонгон шалгаруулж гэрээ хийгдсэн боловч санхүүжилт орж ирээгүй улмаас өглөгийг дээд газрын 2021.01.18-ны 08/49 дугаар албан бичгээр өглөгөөр бүртгэ гэсний дагуу өглөгөөр бүртгэснээс үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 706,131.5 мянган төгрөг болж 121,420.4 мянган төгрөгөөр буурсан нь авлага буурснаас шалтгаалжээ.

Орхон аймгийн ХЭДСангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 639,954.3 мянган төгрөгөөр буюу 49 хувиар буурсан нь Засгийн газрын тусгай сангаас санхүүжих санхүүжилт энэ онд буурсантай холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 363,012.2 мянган төгрөгөөр буюу 38.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, ковид-19-тэй холбоотой зарим төсөл хөтөлбөр хэрэгжээгүйгээс зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,017,235.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 311,503.7 мянган төгрөгөөр бууруулж 705,731.3 мянган төгрөгөөр, Дэлхийн банкны санхүүжилтээр 16,514.0 мянган төгрөг баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72102 /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих/ хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 722,245.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 275,617.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 568,032.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 348,840.1 мянган төгрөг, нийт 916,872.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 572,579.1 мянган төгрөгийг зарцуулж 344,293.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 572,579.1 мянган төгрөг буюу 62.3 хувьтай байгаа нь Ажлын байрыг дэмжих хөтөлбөр 93,315.1 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих 15,280.0 мянган төгрөг, гэх мэт хэрэгжих хөтөлбөр хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 272,885.1 мянган төгрөгийн орлого орж, 267,032.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, 5,853.0 0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 128 мэдээллээс хугацаандаа оруулсан 103 мэдээлэл, хугацаа хоцроосон 25 мэдээлэл байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 429,114.3 мянган төгрөгийн 25 гүйлгээг хугацаа хоцроосон байсныг аудитын явцад залруулж мэдээлэв.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 18,908.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 29.1 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	0	1	0	0	0	29.1
Нийт дүн	1	0	1	0	0	0	0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 451,533.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 429,114.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 13,398.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага тогтоож, 9,020.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчинтой холбоотой шилэн дансны дараах залруулгыг шилэн дансны цахим хуудсанд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 429,114.3 мянган төгрөгийн 25 гүйлгээг хугацаа хоцроосон байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 22,419.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 13,398.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө. Үүнд:

1. Өмнөх оны аудитаар 2017 онд олгосон 18,908.0 мянган төгрөгийн хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэлтэй иргэн, аж ахуй нэгжээс зээлийн төлбөрийг бүрэн барагдуулах зөвлөмж өгсөн боловч бүрэн барагдуулаагүй байгаа нь төсвийн тухай хуулийн төсвийн 6.4.8 төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй, аудитаар аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 9,020.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

2015 онд олгогдсон “Хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн 7 иргэний 4,260.9 мянган төгрөг, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 иргэний 4,760.0 мянган төгрөг, 2017 оны 12 иргэний 3,398.4 мянган төгрөгийн нийт 22,419.39 мянган төгрөгийн хугацаа дууссан зээлийн үлдэгдэл бүрэн төлөгдөөгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах гаргасан зөрчлийг арилгах, цаашид Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.24-ны өдрийн 01/294 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

АУДИТЫН ТАЙЛАНГ



Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

Г.ДАВААСҮРЭН 2021.02.16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.01.28

Аудитын код: ОРА-2021/94/СТА-ТШЗ

Аудитын нэр: Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
(мянган төгрөг)

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2015 онд олгогдсон “Хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн 7 иргэний 4,260.9 мянган төгрөг, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 иргэний 4,760.0 мянган төгрөг, нийт 9,020.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Х.Эрдэнэбат О.Саранчимэг
2	Өмнөх оны аудитаар 2017 онд олгосон 18,908.0 мянган төгрөгийн хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэлтэй иргэн, аж ахуй нэгжээс зээлийн төлбөрийг бүрэн барагдуулах зөвлөмж өгсөн боловч бүрэн барагдуулаагүй байгаа нь төсвийн тухай хуулийн төсвийн 6.4.8 төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй, аудитаар аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.	-	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Х.Эрдэнэбат О.Саранчимэг

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор



Г.Даваасүрэн -г.

Б.Эрдэнэ

Ц.Нармандах